

**БНМАУ-ын ТУСГААР ТОГТНОЛЫГ
ХЭЛЭЛЦЭЖ ТОХИРОЛЦСОН НЬ****Л. Жамсран. Түүхийн ухааны дэд
эрдэмтэн**

ЗХУ фашист Герман улсыг бут цохисны дараа 2—3 сар болоод, Японы эсрэг дайнд орох болзолуудын нэг нь Гадаад Монголын (БНМАУ-ын) статусквог (Одоогийн байгаа байдлыг) хэвээр байлгах явдал байв. 1945 оны 2-р сарын 11-нд Алс Дорнодын асуудлын талаар гурван их гүрний Ялтад байгуулсан хэлэлцээрт энэ зүйлийн талаар дурьдахдаа: «Гадаад Монголын тухай хэлэлцэн тохиролцсон зүйлийг генералассимус Чан Кайши зөвшөөрсөн байх шаардлагатай гэж үзэв.

Маршал Сталин зөвлөснөөр тийм зөвшөөрөл авах арга хэмжээг ерөнхийлөгч авна»¹ гэжээ. Энэ асуудал мөнхүү хэлэлцээрт: «Хятадыг японы дарлалаас чөлөөлөх зорилгоор өөрийн зэвсэгт хүчнээр туслалцаа үзүүлэхийн тулд ЗСБНХУ, Хятадын хооронд найрамдал; холбоо тогтоох тухай Хятадын үндэсний засгийн газартай гэрээ байгуулахад бэлэн байгаагаа Зөвлөлт Холбоот Улс өөрийн зүгээс илэрхийлэв» гэж заасантай нягт холбоотой бөгөөд сүүлчийнхийг шийдвэрлэх явцад хамт шийдэгдсэн билээ.

Монголын ард түмэн үндэснийхээ эрх чөлөөний төлөө хийсэн олон жилийн шаргуу тэмцлийн дүнд 1921 онд ардын ардчилсан хувьсгал ялж, Ар Монгол тусгаар тогтносон улс гэрээ байгуулж, шинэ нийгэм байгуулахын төлөө тэмцэж олсон бодит амжилт, дайн түрэмгийллийн эсрэг тууштай, энх тайванч бодлого явуулсаар ирсэн нь ийнхүү Их гүрнүүдэд хэрэг дээрээ зөвшөөрөгдсөн байна.

Ялтын хэлэлцээрт манай эх орон—БНМАУ-ын тухай орсон заалт Дундад-Зөвлөлтийн найрамдал холбооны тухай гэрээний хэлэлцээнд яаж яригдсан, аль нь ямар санал гаргаж, эцэстээ хэрхэн шийдсэн нь сонирхолтой билээ. Арваад жилийн өмнө Лян Цзиндүй гэдэг зохиогч «Дундад, Зөвлөлтийн найрамдал, Холбооны тухай 1945 оны гэрээний талаар хийсэн хэлэлцээний далд учир» гэдэг өгүүлэл АНУ-д хэвлүүлснийг БНХАУ-д хятад хэлнээ орчуулж «Цзюньши шилинь» (Цэргийн түүхийн түүвэр) сэтгүүлийн 1988 оны 4-рт товчлон хэвлүүлжээ.² Уг өгүүлэлд манай орны талаар бичсэн зүйлийг эх хэлнээ түүвэрлэн орчуулж, ил тод байдлын үзэл санааны дагуу уншигч олондоо лавлах хэрэглэгдэхүүн болгон толилуулж байна.

14 Хуньци, 1981, № 114-р тал

15. Синь цзяньшэ. 1953, № 5, 21-р тал

16. ХКН-ын түүхийн лекц. Бээжин, 1982, 8—15-р тал

17. А. Г. Крымов. 1917-1927 оны Хятад дахь үзэл суртлын тэмцэл ба нийгмийн сэтгэлгээ М., 1962, 23-р тал

18. Ю. М. Гарушянц. Хятад дахь 1919 оны 5-р сарын 4-ний хөдөлгөөн, М., М., 1956, 1971. Хятадын шинэхэн түүх., (1917—1927). М., 1983

19. А. Г. Крымов. 1917—1927 оны Хятад дахь үзэл суртлын тэмцэл ба нийгмийн сэтгэлгээ. М., 1962, 976-р тал

20. Чжунго циннянь, 1924. № 24., 4-р тал

21. Мировая экономика и международные отношения. 1967. № 10, 136-р тал

* * *

«Хятад ба Өрнөдийн улс төрийн бодлоготон ерөнхийлөгч Рузвельт, Генри Уоллес нар хүртэл Хятадын дотоодын дайныг зайлуулахын тулд хамгаас түрүүнд Дундад, Зөвлөлтийн харилцааг заавал сайжруулах хэрэгтэй гэж үзэж байв. Иймээс хорооны дарга¹ Чан Кайши, Засаг захиргааны зөвлөлийн дарга Сүн Цзывэнийг 1944 оны 6-р сараас хожимдолгүй Сталинтай харилцаж, холбоо тогтоон дээр дурдсан зорилгод хүрэх заалт хэдийн өгсөн байв. Тэр үед Хятадын талын хойшлуулшгүй тулгамдсан хамгийн гол асуудал нь Японтой хийж байгаа дайныг дуусгахаас өмнө Зөвлөлт Холбоот Улстай найрамдлын тухай гэрээ байгуулах явдал гэж нийтээр үзэж байв.

Ялтын хэлэлцээр тэр үед дэлхий нийтэд мэдэгдээгүй байсан нь хэн бүхэнд тодорхой. ХКН уг хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш 2 долоо хоногийн дараа түүний нууц агуулгыг илрүүлсэн байхад Дундад улсын засгийн газар нэг сарын дараа өөрийн элчин Гу Вэй цзюнь, Вэй Даомин нараар дамжуулж, тус хэлэлцээрийн холбогдолтой мэдээ олж авсан нь гайхалтай. Вэй Даомин дурсаж ярихдаа: Сталин Ялтын бага хурал дээр Алс Дорнотын асуудлаар ямар бодолтой байв? гэж асуухад, ерөнхийлөгч хариулахдаа: — Сталин гурван зүйлийн санал дэвшүүлсэн.

...Гадаад Монголыг одоогийн байдлаар нь хүлээн зөвшөөрөх, Дундад улс Гадаад Монголын тухайд бүрэн эрхээ хадгалах юм бол Гадаад Монголыг одоогийн байдлаар нь хүлээн зөвшөөрөхөд ямар ч асуудал гарах ёсгүй... хэмээн Рузвельт үзэж байлаа.

Вэй Даомин Ялтын бага хурлаас яг нэг сарын дараа 1945 оны 3-р сарын 12-нд мэдээллээ засгийн газартаа дамжуулсан. Түүний агуулга нь маш товчхон байсан боловч Рузвельт Гадаад Монгол, Дорнод Хятадын төмөр зам, Порт-Артур боомтын асуудлаар хийсэн тайлбарыг тодорхой илэрхийлсэн учраас ЗХУ-ын шаардлагын анхны санааг ойлгоход тус болсон.

АНУ-аас Дундад улсад суугаа элчин сайд Хэрли 1945 оны 5-р сарын 22-нд, Ялтын хэлэлцээрийн агуулгыг Чан Кайшид нууцаар дамжуулаад, хэлэлцээрийн бүрэн эхийг 6-р сарын 15-ны өдөр Дундад улсын засгийн газарт албан ёсоор тушаасан. Чан Кайши түүний агуулгыг мэдсэнийхээ дараа 5-р сарын 22-23-ны өдөр Сүн Цзывэнь, цахилгаан утас явуулж Ван Чунхуй, Гу Вэйцзюнь нартай нууцгай хэлэлцэж нэгэн сөрөг арга хэмжээ авахыг шаардсан. Тэгэхэд тэр гурван хүн Америкт Санфранцискогийн бага хуралд оролцож байсан юм. Сүн Цзывэнь аль эрт 4-р сард АНУ-д очоод Сан-Францискогийн бага хуралд оролцох Дундат улсын төлөөлөгчдийг тэргүүлж байсан юм. Сүн Цзывэнь нь Трумэн, Гопкинс нартай хэлэлцээгээ дуусгаад 6-р сарын 16-нд АНУ-аас мордож, дараа өдөр нь Чунцинд хүрэлцэн ирсэн. Тэр үед хорооны дарга Чан Кайши 6-р сарын 12—16-ны өдрүүдэд Петровтой хоёр удаа уулзахдаа... Гадаад Монголын асуудал хэлэлцэхийг эсэргүүцэж байлаа. Сүн Цзывэнь Чунцинд 10 хоног байхдаа засгийн газрын ноёд түшмэдтэй ЗХУ-д тавих сөрөг арга хэмжээний тухай хэлэлцсэн. Тэр 27-ны өдөр хорооны дарга Чан Кайшигээс Сталинд хүргэх захидлыг аваад, америкийн онгоцоор хөлөглөн Москва орохоор явсан. Түүнийг дагалдан явагчид нь дипломат тусгай төлөөлөгч Цзян Цзинго, ГЯЯ-ны орлогч сайд Ху Шицзэ Манжуурын хэрэг явдлын мэргэжилтэн Шэн Хунле нар байв. 30-ны өдөр Сүн Цзывэнь Москвад, сэтгэл зовиуртай буусан.

Хоёр тал 6-р сарын 30-наас 7-р сарын 12 хүртэл 6 удаа хэлэлцээ хийсэн. 8-р сарын 8-наас 14 хүртэл бас дөрвөн удаа хэлэлцээ хийсэн.

* Гоминданы Төв Гүйцэтгэх Хороог хэлж байна.

Хэлэлцээнд саад гарах тохиолдолд Цзян Цзинго, Сталинтай хувиараа уулзаж шууд ярилцдаг байлаа. АНУ-аас Зөвлөлтөд суугаа элчин сайд Гарриман хэлэлцээний бүхий л үеийн туршид Сүн Цзывэньтэй харилцаар байв.

7-р сарын 2-нд хоёрдахь хэлэлцээ (оройн 8—10 цаг 30 минутад) хийхэд Гадаад Монголын тусгаар тогтнол... Дундад, Зөвлөлтийн найрамдал холбооны тухай гэрээнд холбогдолтой бусад асуудал хамарсан.

Сталин Гадаад Монголын тусгаар тогтнолыг тууштай дэмжиж хэлэхдээ: «Зарим улс Гадаад Монголоор түшиц хийж, ЗХУ-ын Алс Дорнод дахь байр суурийг алдагдуулахыг оролдож байна. Хэрэв ЗХУ, Гадаад Монгол маягийн бамбай бүс нутаггүй байх юм бол Алс Дорнодын нутаг дэвсгэрээ хамгаалж чадахгүй. Японыг даруй буулгалаа ч гэсэн 5—10 жилийн дараа дахин өндийн босч ирнэ. Гадаад Монголын ард түмэн Дундад Улстай нэгдэхэд дургүй. ЗХУ-тай нэгдэхэд ч бас дургүй. Иймээс тусгаар тогтновол зохино. Тэр ч байтугай зарим Гадаад Монгол хүн Өвөр Монголыг тухирч нэгэн бүгд найрамдах их Монгол улс байгуулах гэж байна. Хэрэв ийм байдал үүсвэл Хойт Хятадад аюул учруулна. Иймээс Дундад улсын ашиг тусын үүднээс бодвол Гадаад Монголыг тусгаар тогтноулах нь бас бүр ч ашиг тустай болох юм» гэсэн. Сүн Цзывэнь Дундад улсын засгийн газар хэрхэвч нутаг дэвсгэрээ хаяхгүй. Эс тэгвэл ард түмэндээ итгэл алдана. Дундад иргэн улсын засгийн газар Сүн Ятсены үеэс эхлэн Дундад Улсын ард түмэнд Гадаад Монголыг оролцуулсан нутаг дэвсгэрээ бүхэл бүтэн байлгах баталгаа гаргаж ирсэн гэж мэдэгдсэн.

Сталин санал гаргахдаа: Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлын тухай нууц хэлэлцээрт гарын үсэг зураад, Японыг бууж өгсөний дараа жич зарлая гэсэн. Хэрэв Гадаад Монголыг Дундад Улсын нутгийн нэг хэсэг байсаар байх юм бол тэнд ЗХУ-ын цэрэг байлгах явдал зөвшөөрөгдөхгүй. ЗХУ-ын батлан хамгаалах шугам аюултай тулгарна хэмээн улам бүр онцлон шаардаж байлаа. Гэтэл Сүн Цзывэнь Дундад улсын засгийн газрын дараагийн зааврыг хүлээж аваагүй байхдаа Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлаар буулт хийхгүй байв.

Иймд Гадаад Монголын асуудал Чунцинд дахин мэдээлэгдэж заавар авахаар болов.

Сүн Цзывэнь Чунцин хотоос Москва руу мордохын өмнө, Дундад улсын засгийн газар түүнд ЗХУ-тай хийх хэлэлцээний чиглэлийг зааж өгсөн юм. Асуудлын зангилаа хоёр зүйл нь түрээслүүлэх эрх, нутаг дэвсгэрийн эрх юм. Тэр үед Дундад улсын тал Гадаад Монголын асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байлаа. Учир нь ЗХУ зөвхөн одоогийн байдлыг хэвээр байлгах шаардлага тавьж байсан юм. Дундад Улсын ойлголт Рузвельтын нотолгоогоор авч үзвэл: Дундад улсын бүрэн эрхийг хадгална гэсэн учраас ямар нэгэн маргаан үүсэхгүй билээ. Гэтэл одоо болохоор Гадаад Монголын асуудал хэлэлцээний гол асуудал болов.

Сүн Цзывэнь аргагүйн эрхэнд дор дурдсан хэдэн зүйлийн төслийг дэвшүүлж болох эсэхийг Чан Кайшид тавьсан. Үүнд:

1. Гэрээгээр тогтоосон хугацааны дотор ЗХУ-ыг Гадаад Монголд цэргээ байлгахыг зөвшөөрч болох эсэх,

2. Гадаад Монголд өөртөө засах эрх олгон, ЗХУ-ын цэрэг тэнд байхыг зөвшөөрч болох эсэх.

3. Дундад Улс эзэн эрх (Сюзеренитет) -ээ хадгалж байгаа нөхцөлд Гадаад Монголыг тусгаар тогтноулж, цэргийн болон дотоод хэргээ шийдвэрлэж байхыг зөвшөөрч болох эсэх.

Сун Цзывэнийн цахилгаан утас Чунцинд хүрэх үед Чан Кайши Сиань руу явчихаад байсан тул тэр дор нь хариу өгч чадсангүй. Сталины шаардлага нь Ялтын хэлэлцээрийн заалтаас хэтэрснээр барахгүй АНУ-ын нээлттэй бодлоготой харилцан зөрчилдөж байгаа учраас Сун Цзывэнь дэгийг харж, АНУ-аас ЗХУ-д суугаа элчин сайд Гарриمانыг Дундад улсын төлөөлөгчид байрласан газар урьж ирүүлэн, түүнд ЗХУ-тай хийж байгаа хэлэлцээний явцыг мэдээлж, АНУ-ын Төрийн департамент, Ялтын хэлэлцээрт гарын үсэг зурсан нэг гүрний хувьд хэлэлцээрийн тухай зөв тайлбар өгч Сталинтай цаашид хийх хэлэлцээнд үндэс болгохыг гуйсан ажээ. Энэ үед АНУ-ын Төрийн департаментэд өөрчлөлт орж Джеймс Ф. Бирнс төрийн нарийн бичгийн дарга болсон. Тэр Алс Дорнодын хэрэг явдлыг сайн мэдэхгүйгээс гадна тэр үеийн АНУ-ын бодлого бол ЗХУ-тай ямар нэгэн мөргөлдөөн гаргахаас зайлсхийж байсан учраас Төрийн департамент Гарриманы тавьсан асуудлыг цэвэр Дундад, Зөвлөлтийн хоорондын хэрэг тул АНУ-ын тал хэлэх зүйлгүй гэсэн.

Чунцингийн шинэ зааврыг тэсч ядан хүлээх зуур Сун Цзывэнь, Цзян Цзинго-г Сталинд бараалхаж хувиараа ярилцахыг хүссэн, Сталин хэлэхдээ: Дундад улс японы түрэмгий цэргийг үлдэн зайлуулах хүчин үгүй байгаа болохоор ЗХУ-г заавал түшиглэх хэрэгтэй. Иймээс Дундад улс ЗХУ-ын шаардлагад буулт хийх нь цорын ганц зохистой арга мөн. ЗХУ-ын чухамхүү санаа Сталин, Цзян Цзинго нарын ярилцлагад баараггүй гарсан. Сталин хэлэхдээ: «Танд үнэн үг хэлье. Стратегийн үүднээс авч үзэхэд нь аль нэгэн цэрэгжсэн их гүрэн Гадаад Монголоос ЗХУ-ыг довтолж Сибирийн төмөр замыг таслах юм бол ЗХУ өнгөрөх нь тэр... Япон, Дундад улсын алинд нь ч Гадаад Монголыг эзлэж чадах хүч байхгүй гэж сая хэллээ. Гэвч та аль нэг гурав дахь их гүрэн үүнийг хийж чадахгүй гэж хэлж чадах уу? «Тэр их гүрэн чинь ямар улс вэ? АНУ уу?» гэж Цзян Цзинго сөргүүлж асуухад: Сталин «тийм» гэж хариулав. 1945 онд Дундад улсын үхээнц дорой, Сталины хар санаа, Рузвельтийн гэнэн, Трумэны мэдлэггүй нь дайны дараахь Алс Дорнодын гай гамшгийн гол хүчин зүйлс болсныг түүхийн тэмдэглэлүүдээс тодорхой харж болно.

Чунцингийн шинэ заавар хугацаандаа ирээгүй, хэлэлцэх хугацааг цааш нь сунгаж болохгүй учраас гурав дахь хуралдаан дээр Сун Цзывэнь зөвхөн нэг сөрөг санал гаргахдаа: Дундад улсын засгийн газар Гадаад Монголын өөртөө засахыг (автономийг) зөвшөөрч болно. Гэхдээ Дундад Улсын эзэн эрхийг орхихгүй гэв.

Гуравдахь хуралдаан 7-р сарын 7-ны шөнө 11 цагаас 11 цаг 45 минутанд явагдсан. Сун Цзывэнь хэлсэн үгэндээ: Ялтын хэлэлцээрт зөвхөн «Гадаад Монголын одоогийн байдлыг хадгална» гэснээс биш Гадаад Монголыг тусгаар тогтноулна гэж хэлээгүй гэхэд Сталин тайлбарлахдаа: Өнөөдрийн Гадаад Монгол бол хэрэг дээрээ нэгэн «Ардын бүгд найрамдах улс» юм. Одоогийн байдал гэгч нь «тусгаар тогтнол»-ыг хэлж байгаа юм. Хэсэг зуур маргалдсаны дараа Сун Цзывэнь, Дундад Улс, Гадаад Монголд өндөр зэргийн өөртөө засах эрх олгож, өөрийн цэрэг ба гадаад харилцааны хэргээ өөрсдөө шийдвэрлэх, тэр ч байтугай ЗХУ-тай гэрээ байгуулж болно. Зөвлөлтийн цэрэг Гадаад Монголын нутагт байж Сибирь нутгаа хамгаалж байж болно гэдэг санал дэвшүүлэв. Гэтэл Сталин энэ төслийг урьдын адил эсэргүүцэв. Эцэст нь хуралдаанд хандаж Дундад, Зөвлөлтийн хэлэлцээний дөрвөн баримт бичгийн төслийг дэвшүүлэн тавив. Үүнд: Найрамдал холбооны тухай гэрээ, Дорнод Хятадын төмөр зам ба Өмнөт Манжуурын төмөр замын тухай хэлэлцээр, Порт-

Артур ба Дальний тухай хэлэлцээр, Гадаад Монголын тусгаар тогтнолын тунхаг.

Дундад улсын засгийн газрын зөвшөөрөлгүйгээр Гадаад Монголын тусгаар тогтнолын тунхагийг хэлэлцэж болохгүй гэж Сүн Цзывэнь тууштай зогсож байв. Тэгэхэд Сталин хариу болгож хэлэхдээ: Гадаад Монголын тусгаар тогтнолын тунхагийг хэлэлцэхгүй юм бол Дундад, Зөвлөлтийн Холбооны тухай гэрээг бас хэлэлцэх шаардлагагүй гэсэн. Тэгэхэд ширүүн маргалдаан болсныг дараахь тэмдэглэлээс үзэж болно.

Сүн Цзывэнь: Гадаад Монголын тухай асуудлаар бид хэдийн бодитой санал дэвшүүлсэн.

Сталин: Та нарын санал чинь бодитой биш,

Сүн Цзывэнь: Манай засгийн газрын бодлогын үүднээс ярих юм бол, тэгж хийх нь бодитой болно.

Сталин: Гэвч бид зөвшөөрөхгүй.

Сүн Цзывэнь: Миний хүлээн авсан заавар ийм л байгаа юм.

Сталин: Тэгвэл бид энд хүрээд хэлэлцээгээ зогсооё л доо.

Сүн Цзывэнь: Эрхэмсэг ноён манай байр суурийг ойлгож чадахгүй байгаад би гүнээ харамсаж байна.

Сталин: Эрхэмсэг ноён бидний байр суурийг ойлгож чадахгүй байгаад би бас гүнээ харамсаж байна. Үүгээр төгсгөө дөө.

Дундад, Зөвлөлтийн хэлэлцээ үзтэл тасрахад хүрэв. Хоёрдахь хуралдааны тухай Сүн Цзывэнийн мэдээллийг 7-р сарын 3-нд хүлээн авсныхаа дараа Чан Кайши Чунцинд буцаж ирээд дээд тушаалын ноёдыг зарлан хуралдуулж бүхий л байдлыг хэлэлцүүлэв. 5-ны шөнө Сүн Цзывэнь рүү шинэ заавар явуулсны гол агуулга нь:

1. Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлыг, манай улсын нэгдэл, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сэргээтэл азнаж дараа хэлэлцэж шийдэх.

2. Хэрэв ЗХУ манай улсын Манжуурын бүрэн эрх нутаг дэвсгэрийн бүхэл бүтэн байдалд баталгаа өгч, ХКН-ын хуйвалдааныг дэмжихгүй, Синьцзянд самуун өдөөхгүй бол манай улсын засгийн газар, Гадаад Монголд ард иргэдийн санал хураалт явуулж түүний тусгаар тогтнолыг хэрэгжүүлэх санал дэвшүүлэх хүсэлтэй байна. Гэхдээ энэ хэргийг Японыг эсэргүүцсэн дайнд ялсны дараа гүйцэтгэх болно...

АНУ-аас ЗХУ-д суугаа элчин сайд Гарриман, Сүн Цзывэньтэй нууц харилцаж тэр өөрийн туршлагаасаа үндэслэн үзэхдээ: ЗХУ-тай хэлэлцээ хийхдээ, нэг гэрээгээр бүх асуудлыг шийдвэрлэх гэсний хэрэггүй. Хэрэв Дундад, Зөвлөлтийн хэлэлцээ тасарвал, ЗХУ, Японтой хийх дайнаараа далимдуулан Манжуур, Өвөр Монголд тэр ч байтугай Дундад Улсын уугуул нутаг руу түрэмгийлэн орно. Дундад Зөвлөлтийн гэрээг байгуулахгүй юм бол Дундад улсад нэн ашиггүй болж магадгүй гэв.

Цзян Цзинго ЗХУ-ын ажилтнуудтай хувиараа уулзах байхдаа:

Сталин Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлаар огт ухрахгүй тууштай байна. Хэрэв Дундад улсын тал энэ асуудлаар жаахан амжилт олъё гэвэл буулт хийж, хариуд нь ЗХУ-аар Дундад иргэн улсын засгийн газарт туслуулж Дундад улсыг нэгтгэж болно гэсэн ойлголт авав.

Сүн Цзы Вэнь ийм санаа өвөрлөөд, дөрөвдэх хуралдаан хийхийг Сталинаас шаардав. Дөрөвдэх хуралдаан 7-р сарын 9-нд болж зөвхөн 100 минут (орой 9 цагаас 10 цаг 40 минут хүртэл) болсон боловч бүхий л хэлэлцээнд эргэлт болов. Сүн Цзывэнь Чунцингийн шинэ зааврыг баримтлан Сталинд ёс төртэй хэлэхдээ: «Талийгаач Сүн Ятсен авгайн гэрээслэлийг мөрдөн дагаж Дундад, Зөвлөлтийн сайны

харилцааг баталгаатай болгож, хоёр орныг ажил хэрэгч хамтын ажиллагаатай болгохын тулд Дундад улсын засгийн газар хамгийн их хохирол хүлээх хүсэлтэй байна. Дундад улсын өнөөдрийн шаардлага бол бүрэн эрх нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хийгээд улс орны жинхэнэ нэгдлийг бий болгох явдал юм. ЗХУ Дундад улсыг талархан хамтран ажиллах, туслан дэмжиж чадахаа даруй илэрхийлж Дундад улсад доорхи зүйлүүдийн баталгаа өгнө үү?

«Дээр дурдсан гурван зүйлийн саналыг ЗХУ зөвшөөрснийг урьдчилсан нөхцөл болгож Дундад улсын засгийн газар Японыг бут цохисны дараа, Гадаад Монголын ард иргэдийн санал хураалт явуулж Гадаад Монголын тусгаар тогтнолыг шийдвэрлэхээр бэлтгэж байна, Гадаад Монголын хилийг тогтоохдоо Дундад улсад угийн байгаа газрын зургийг үндэс болгоно» гэжээ.

Үүнээс урьд хэлэлцсэн хоёр тал гол асуудлын талаар санал нэгдээд бусад үлдсэн зарим асуудлаар дахин хэлэлцэж тохирох хэрэгтэй байв.

Сталин, Молотов нар Москвагаас Потсдамын бага хуралд оролцохоор явахын өмнө хэлэлцээг дуусгахыг хүсэж байсан учраас тав дахь, зургаадахь хуралдаан маш амжилттай явагдсан. Зургаадахь хуралдаан 7-р сарын 12-нд (12—12 цаг 45 минутанд) болов. Хоёр тал Гадаад Монголын тусгаар тогтнолын тунхаг болон Дундад Зөвлөлтийн найрамдал, холбооны тухай гэрээний хоёр төслийг хэлэлцэн тохиров.

Сталин, Молотов нар 7-р сарын 14-нд Москвагаас мордож Потсдамын бага хуралд оролцох учир, Сун Цзывэнь энэ хугацааг ашиглан Петров нарын зэрэг хүмүүстэй хамт Чунцин рүү түр буцаж Дундад улсын засгийн газарт хэлэлцээний үр дүнг илтгээд ЗХУ-ын удирдагчид Москвад буцаж ирсний дараа Дундад улсын төлөөлөгчид дахин ирж хэлэлцээг үргэлжлүүлэх санал тавив. Молотов энэ саналд эргэлзэж, харин... Сталин сайшаав. 14-ний өдөр Сун Цзывэнь, Цзян Цзинго нар Петровтой хамт Чунцин рүү буцаж нисэв.

Хү Шицзэ Москвад үлдэж ЗХУ-ын төлөөлөгчидтэй хэлэлцээг үргэлжлүүлэв.

Сүн Цзывэнь хэлэлцээний өрнөлтийн үед гэнэт улсдаа буцаж ирсэн нь чухал учир шалтгаантай.

1. Дундад улс нь гагцхүү Манжуур, Гадаад Монголын зарим эрх ашгийг золиослох нөхцөлд Дундад, Зөвлөлтийн найрамдал, холбооны тухай гэрээг сая байгуулж чадна гэж Сүн Цзывэнь бүрэн ойлгож байсан бөгөөд иймэрхүү болзол бүхий гэрээнд гарын үсэг зурах дургүй байжээ. Иймээс тэр Москва руу буцахынхаа өмнө Чан Кайшид шинээр ГЯЯ-ны сайд томилж, өөрийнхөө орноос гэрээнд гарын үсэг зуруулахыг шаардсан ажээ.

2. ЗХУ-аас Гадаад Монгол, Манжуурын талаар тавьж байгаа шаардлага нь гурван гүрний Ялтын хэлэлцээрийн заалтаас давж хэтэрлээ гэж ойлгож байв. Гадаад Монголын тусгаар тогтнол АНУ-д хэдийгээр холбогдолгүй боловч ЗХУ, Манжуур дахь эрх ашгийг ганцаараа ноёрхох санаа агуулж байгаа нь АНУ-ын нээлттэй бодлоготой харшлаж байгаа тул АНУ-ын засгийн газар үүнийг ойшоохгүй байж болохгүй.

Трумэн, Сталин нар Потсдамд уулзах нь АНУ-д байдлыг шинээр харгалзан үзэх чухал боломж өгнө. Хэрэв АНУ-ын засгийн газар, Дундад улсын өмнөөс хэдэн үг хэлж ЗХУ-ын хэрээс хэтэрсэн шаардлагыг зохицуулбал түүний үр дүн нь Дундад улсын тал дангаараа дэвшүүлж буй сөрөг арга хэмжээнээс хавьгүй илүү сайн болно гэж Сүн Цзывэнь үзэж байна.

Гэтэл хэргийн бодит байдал санасанчилан бүтсэнгүй, Потсдамын бага хурал 8-р сарын 2-ны өдөр дууссан. Сталин, Молотов нар 8-р сарын 5-нд Москвад буцаж ирсэн. Сүн Цзывэнь, Ван Шицзе (Дөнгөж сая томилогдсон Дундад улсын ГЯЯ-ны сайд), Петров (ЗХУ-аас Хятадад суугаа элчин сайд), Цзян Цзинго, Сюн Шихуй (шинэ томилогдсон төлөөлөгч, зүүн хойт нутгийн цэргийн эрхтэн болгохоор төлөвлөж байсан) нар 8-р сарын 6-нд Чүнцингээс мордож, дараа өдрийн орой 7 цаг 30 минутанд Москвад хүрэлцэн ирсэн. Түүрүүчийн хуралдаанаас хойш 3 долоо хоног өнгөрч байлаа.

Дахин эхэлсэн Дундат, Зөвлөлтийн хэлэлцээ маш түргэн явагдав. 7, 8, 9 дахь хуралдаанууд 8-р сарын 8, 9, 13-ны өдрүүдэд болов. 14-ний 10 дахь хуралдаанаар хамгийн сүүлчийн шийдвэр гаргаж, найман зүйлээс бүрэлдсэн найрамдал, холбооны тухай гэрээ, харилцан солилцсон тусгай дөрвөн зүйлийн ноот, нэгэн санамж бичигт Дундад улсын ГЯЯ-ны сайд Ван Шицзе, ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Молотов нар гарын үсэг зурав.

Хамгийн сүүлд дор дурдсан гол зүйлүүдийг хэлэлцэн тохиролцов.

Гадаад Монголын тухайд

Японыг ялсны дараа, Гадаад Монголд ард иргэдийн санал хураалт явуулахыг Дундад улсын засгийн газар зөвшөөрөв. Түүний ард иргэд тусгаар тогтнолыг сайшаах эсэхээ шийдвэрлэнэ. Хэрэв ард иргэдийн санал хураалтын дүн тусгаар тогтнолыг сайшаавал Дундад улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, түүний хилийг хэвээр байлгана.

Сүүлчийн нэг өдөр, тухайлбал: 8-р сарын 13-ны өдөр Чан Кай Ши Дундад улсын төлөөлөгчдийн гуйлтыг зөвшөөрөв. Ийнхүү арав дахь хуралдааны үед Сүн Цзывэнь, Ван Шицзе нар ЗХУ-ын төлөөлөгчидтэй Гадаад Монголын хил, Порт-Артур бааз дахь Дундад, Зөвлөлтийн цэргийн комиссын асуудлуудаар хэлэлцэн тохиролцож харилцан ойлголцов» гэж уг өгүүлэлд бичжээ.

* * *

1945 оны 8-р сарын 14-нд Дундат улсын ГЯЯ-ны сайд Ван Шицзе, ЗХУ-ын Гадаад хэргийн Ардын Комиссар В. М. Молотовт гардуулсан ноотдоо: «Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнохыг удаа дараагаар хүсч эрмэлзсэн учир дундат улсын засгийн газраас илэрхийлэх нь Японыг дарсны дараа Гадаад Монголын ард түмний нийтийн хүсэл энэ эрмэлзлэлээ батлах ахул Дундад улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрч байна.

Дээр дурдсан илэрхийлэл нь Дундат Иргэн улс СССР хоёрын хооронд 1945 оны 8-р сарын 14-нд байгуулсан холбоо найрамдлын тухай гэрээ батлагдмагц заавал хүчин төгөлдөр болно» гэсэн.

ЗХУ-ын Гадаад хэргийн Ардын комиссараас мөн өдөр ДИУ-ын ГЯЯ-ны сайдад гардуулсан ноотдоо: «Зөвлөлт засгийн газар Дундат Иргэн Улсын засгийн газрын дээр тодорхойлсон ноот бичгийг сэтгэл ханамжтай хүлээн авч өөрийн зүгээс илэрхийлэх нь, тус Зөвлөлт Засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улс (Гадаад Монгол)-ын төрийн тусгаар тогтнол ба нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзнэ»³ гэсэн.

Ингэж хэлэлцэн тохирсоны үндсэн дээр Японы милитаризмыг бут цохисны дараа 1945 оны 10-р сарын 20-нд БНМАУ-д санал хураалт явуулахад хот, хөдөөгийн сонгуулийн эрхтэй бүх хүмүүсийн

97,8% нь өөрийн улсын тусгаар тогтнолыг санал нэгтэй сайшааж, батлан гарын үсгээ зурцгаасан. Энэхүү санал хураалтыг ажиглах тусгай төлөөлөгчид ДИУ-аас ирж тус улсын ард түмэн байлдан олсон тусгаар тогтнолоо бататган хадгалах зориг эрмэлзлэл төгс нэгдмэл саналтай байгааг нүдээр үзсэнээ засгийн газартаа уламжлахаа албан ёсоор мэдэгдсэн билээ.

ДИУ 1945 оны 1-р сарын 5-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээж, улмаар 1946 оны 2-р сарын 13-нд тус хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон юм. Энэ нь манай ард түмэн төрийн тусгаар тогтнолоо байлдан олж, шинэ амьдралаа цогцлон байгуулахын тулд шаргуу тэмцэж, үгүйсгэшгүй амжилтанд хүрсэн, манай засгийн газраас хувьсгалт Монгол улс, ДИУ-ын хооронд хэвийн харилцаа тогтоох явдалд зуучилж өгөхийг бүр 1921 оны 9-р сард хүссэний дагуу ЗХУ-ын хийсэн нөр их чармайсны үр дүн, Хятадын дэвшилт, хувьсгалт олон түмэн монголын тусгаар тогтнолыг дэмжиж, засгийн газартаа ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн зэргээр тайлбарлагдана.

БНХАУ-ын ШИНЭТГЭЛИЙН ҮЕИЙН ГАДААД БОДЛОГО (1979—1989)

Л. Бэгзжав

Аливаа улсын гадаад бодлого дотоод бодлогынхоо үргэлжлэл төдийгүй тухайн улсынхаа стратеги бодлогын нэг хэсэг байдаг. 80-аад оны үед БНХАУ-ын гадаад бодлого тус орны дотоод улс төрийн арга хэмжээ, олон улсын байдлын нааштай өөрчлөлттэй холбоотой явж ирлээ. «Гадаад бодлогыг дотоод бодлогоос салгаж үзэхээс илүү хортой үзэл байхгүй»¹ гэж В. И. Ленин тэмдэглэсэн билээ. Үнэхээр тус орны шинэтгэлийн үеийн гадаад бодлого ХКН-аас дэвшүүлсэн «Хятадын онцлогтой социализм» байгуулах стратеги зорилттой нягт уялсан даатай, харилцан шүтэлцээтэй байгаа юм. 70-аад оны эцсээс эхлэн БНХАУ үйлдвэрлэх хүчнээ хөгжүүлэх, аж ахуйн үр ашигтай механизм бий болгох, улс орныхоо шинжлэх ухаан-техникийн чадавхийг орчин үеийн түвшинд хүргэх зорилго бүхий шинэтгэл хийж эхэлсэн билээ. Өргөн цар хүрээтэй, урт удаан хугацаа шаардсан шинэтгэлийн энэ зорилтыг хэрэгжүүлэхэд юуны өмнө, гадаад ертөнцтэй харилцаагаа өргөжүүлэх явдал тус орны өмнө тавигдсан юм.

ХКН-ын 1978 оны XII сарын III бүгд хурал 1979 оноос эхлэн нам, ард түмний анхаарлыг социалист дөрвөн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх болов. Ингэхдээ дотооддоо эдийн засгийн шинэтгэл хийх, гадаадад нээлттэй байх бодлого дэвшүүлсэн юм. Хятадын хөгжлийн стратегийг боловсруулан гаргахдаа «асуудалд бодитой хандах», гадаад бодлогодоо ангич байр суурь, нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг гол болголгүй, харин эдийн засгийн хувьд

1. Тегеран. Ялта. Потсдам. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1973. 216 217-рт
2. «Цзюньши шилинь» сэтгүүл, Бээжин, 1988, 36—43—49-рт
3. «Үнэн» сонин, 1945, VIII. 29